



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2016 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот


**Аудитын сэдэв батлах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Төрийн аудитын байгууллагаас 2016 онд хийх аудитын сэдвийг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад заасан аудитын сэдвийг үндэслэн 2016 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулж, биелэлтэд хяналт тавьж мөрдөж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудитор А.Зангадад үүрэг болгосугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Ч.УЛААН

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2016 оны 1 дугаар сарын 12 ны өдрийн 101 дүгээр тогтоолын хавсралт

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААС 2016 ОНД ХИЙХ АУДИТЫН СЭДВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Аудитын сэдэв	Хамрах хүрээ (ТЭЗ)	Аудит хийх хугацаа			
		Эхлэх	Дуусах	УИХ-д хүргүүлэх	
<b>2015 оноос 2016 он дамжин хийх аудитын сэдэв</b>					
1.	Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, хэрэгжилт, үр дүн	УУЯ, БОНХЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ	2015.08.20	2015.12.20	2016.01.10
2.	Төрийн өмчит их, дээд сургуулиудын 2013-2014 оны үйл ажиллагааны үр дүн	БШУЯ, төрийн өмчит их дээд сургуулиуд	2015.09.20	2015.12.20	2016.02.25
3.	Хамтарсан үйлдвэрүүдийн үйл ажиллагааны үр дүн	Монгол-Оросын хамтарсан УБ төмөр зам ХНН	2015.08.20	2016.03.20	2016.03.31
<b>Хуулийн дагуу хийх аудитын сэдэв</b>					
4.	2015 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн	Улс болон орон нутгийн ТЭЗ нар	2016.01.13	2016.06.10	2016.06.10
5.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт	Засгийн газар улсын төсвийн ерөнхийлөн захирагчид	2016.01.13	2016.03.31	2016.04.01
6.	Монгол Улсын 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл	Улс, орон нутгийн болон Нийгмийн даатгал, Хүний хөгжил сангийн ТЭЗ	2016.05.10	2016.06.10	2015.06.10
7.	2017 оны Монгол Улсын төсвийн төсөлд санал өгөх	Улсын төсөв, Нийгмийн даатгал, Хүний хөгжил сангийн ТЭЗ-д	2016.09.15	2016.10.14	2016.10.15
8.	Намуудын мөрийн хөтөлбөрт аудит хийх	УИХ-ын сонгуульд оролцох улс төрийн намууд	УИХ-аар сонгуулийг товлон зарласан үед хугацаа тодорхой болно.		
9.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл	Сонгуулийн ерөнхий хороо, сонгуулийн тойргийн хороод болон салбар, хэсгийн хороо	УИХ-аар сонгуулийг товлон зарласан үед хугацаа тодорхой болно.		
10.	Орон нутгийн хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл	Сонгуулийн ерөнхий хороо, сонгуулийн тойргийн хороод болон салбар, хэсгийн хороо	УИХ-аар сонгуулийг товлон зарласан үед хугацаа тодорхой болно.		
11.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Төрийн захиргааны газрууд, яамд, нийслэл,	2016.01.23	2016.05.30	2016.06.25

		аймаг, сум, дүүргийн төсвийн байгууллагууд, төрийн өмчит компаниуд	2016.10.01	2016.11.30	2017.01.15
12.	Орон нутгийг хөгжүүлэх сангийн зарцуулалт	Аймаг, нийслэл, сум, дүүргийг хөгжүүлэх сангууд	2016.01.18	2016.05.25	2016.06.10
<b>Шинээр хийх аудитын сэдэв</b>					
13.	Улсын төсвөөс эргэж төлөгдөх нөхцлөөр олгосон хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлт, үр дүн	Сангийн яам болон бусад холбогдох яам, байгууллагууд	2016.01.13	2016.06.10	2016.06.15
14.	Улсын нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалтын дүн	Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газар, орон нутаг дахь улсын нөөцийн салбарууд	2016.04.01	2016.06.24	2016.07.16
15.	Улсын төсөвт үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны үр дүн	Засгийн газар, Төрийн өмчийн хороо, улсын төсөвт үйлдвэрийн газар	2016.08.15	2018.11.15	2016.11.25
16.	Хамтарсан үйлдвэрүүдийн үйл ажиллагааны үр дүн	Монголросцветмет ХХК	2016.11.15	2017.06.15	2017.07.01
17.	Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилт	БОАЖЯ, аймаг нийслэлийн байгаль орчны газрууд	2016.08.15	2016.11.15	2016.11.25
18.	Эрчим хүч, харилцаа холбооны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа, үр дүн	ЭХЗХ, ХХЗХ	2016.01.15	2016.05.01	2016.05.15
19.	Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн	4-5 санд аудит хийх	2016.06.23	2016.10.15	2016.11.11
20.	"Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт" ТББ-ын хэрэгжүүлж буй хуульд заасан төрийн чиг үүргийн хэрэгжилт	"Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт" ТББ, Сангийн яам	2016.08.15	2016.11.15	2016.11.25